



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

“Нэйшнл лайф даатгал” ХХК-д
насан туршийн даатгалын хэлбэрийн
зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 3.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Нэйшнл лайф даатгал” ХХК-д насан туршийн даатгалын /2.2/ хэлбэрээр урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэмж олгосугай.
2. Насан туршийн даатгалын хэлбэрээр анхны гэрээ байгуулах үедээ Хороонд мэдэгдэхийг “Нэйшнл лайф даатгал” ХХК /Г.Монголхүү/-д үүрэг болгосугай.
3. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавьж, “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад насан туршийн даатгалын хэлбэрийг нэмж бүртгэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



000013